

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.МЭНДЭЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн асуудал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх асуудлыг бодлого төлөвлөлтөд тусгах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах”							
1	Арга хэмжээ 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төслийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан комиссын дүрмийн төслийг шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган шинэчлэн боловсруулж байна. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр аймаг дүүргийн салбар комиссын нарийн бичгүүдтэй цахим уулзалт, 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр төрийн бус байгууллагын саналыг тусгах хэлэлцүүлгийн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан. Мөн холбогдох, төрийн байгууллага, салбар комиссын гишүүдийн 2 саналыг цахим шуудангаар хүлээн авч тусган боловсруулж байна.	10-12	80%

Дэд арга хэмжээ: 1.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төслийг боловсруулах холбогдох төрийн болон ТББ, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулж саналыг дүрмийн төсөлд тусгах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	30%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөлд холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс 20 санал, төрийн байгууллагаас 4 санал, мөн салбар комиссын гишүүдийн саналыг цахим шуудангаар хүлээн авч нэгтгэн тусган боловсруулав.	10-12	80%
Дэд арга хэмжээ: 1.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төслийг хэлэлцүүлэх салбар дундын уулзалтыг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	50%	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан комиссын дүрэмд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган шинэчлэн боловсруулж байна. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр аймаг дүүргийн салбар комиссын 30 нарийн бичиг нартай цахим уулзалтыг зохион байгуулж төсөлд тусгах саналуудын талаар ярилцаж хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан. Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн тусгах боломжтой саналуудыг авч тусгаж ажилласан.	10-12	80%
Дэд арга хэмжээ: 1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөлд саналуудыг нэгтгэн	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”- ийн төслийг танилцуулах, төрийн болон төрийн бус байгууллагын саналыг тусгах хэлэлцүүлгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 26 хүний бүрэлдэхүүнтэй Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 317 тоот өрөөнд зохион	10-12	60%

	хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах				байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн дүрмийн төсөлд тусган холбогдох яамдад хүргүүлэхээр бэлтгэж байна.		
Зорилт 2. “Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт болон үнэлгээний арга аргачлал, хөгжлийн дэмжлэгийн хөтөлбөр, шаардлагатай дүрэм, журам, стандарт боловсруулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих”							
2	Арга хэмжээ 2.1. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хөгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Мэдээллийн нэгдсэн сан”-г хүлээж авах ажлыг зохион байгуулах	Программ-1	0%	100%	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг WWW.CWD.MLSP.GOV.MN Домэйн нэрээр төрийн мэдээлэл солилцооны “ХУР” болон E-Mongolia системтэй холбож, дүүргүүдийн салбар комиссын нарийн бичиг нарт нэвтрэх эрх үүсгэн салбар комиссын ээлжит хуралд туршин ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар мэдээллийн санг бүрэн ашиглахад хүүхдийн мэдээлэл дуудаж байгаа хурд муу байгаа учир сайжруулах шаардлагатай байгаа. Мэдээллийн санг бүрэн ашиглалтад оруулснаар дараах ач холбогдолтой. Үүнд: - Салбар комиссын ээлжит хурал, кейс хэлэлцүүлгийн мэдээллийг оруулж, тайлан хэвлэх боломжтой. - Хүүхдүүдийн мэдээллийг санд нэгтгэх боломжтой. - Төрийн мэдээлэл солилцооны системүүдээс зорилтот хүүхдийн үндсэн мэдээллийг татах боломжтой. - Сургалтын видео лекцүүдийг байршуулсан бөгөөд сургалтад тогтмол ашиглах боломжтой.	10-12	80%

	Дэд арга хэмжээ: 2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг турших ажлыг зохион байгуулах	Туршилтын тоо	0%	2	Мэдээллийн санг Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүргүүдийн салбар комиссын нарийн бичиг нарт нэвтрэх эрх үүсгэн салбар комиссын ээлжит хуралд туршин ашиглаж эхэлсэн. Цаашид гарсан асуудлуудыг сайжруулан аймгуудын салбар комисст туршихаар бэлдэж байна.	10-12	80%
	Дэд арга хэмжээ: 2.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг хүлээж авах, сангийн журмын төслийг боловсруулах	1 төсөл	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журмын төслийг боловсруулан санал авахаар бэлтгэж байна.	10-12	70%
Зорилт 3. “Аймаг, дүүргийн Салбар комиссын гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, заавар, зөвлөмж, үйл ажиллагааны чиглэл өгөх, хяналт тавих”							
3	Арга хэмжээ 3.1. Салбар комисст мэргэжлийн дэмжлэг үзүүлж, зөвлөмж, чиглэлээр хангаж ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	60%	2024 оны байдлаар нийслэлийн 6 дүүргийн салбар комиссын гишүүдтэй сал2 удаагийн уулзалт, 21 аймаг 9 дүүргийн салбар комиссын нарийн бичгийн дарга нарт зориулан 2 удаагийн онлайн сургалтыг тус тус хийсэн. Салбар комиссын гишүүдийг шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүр ханган ажиллаж байна.	10-12	80%
4	Арга хэмжээ 3.2. Салбар комиссын улирлын тайланг хуваарийн дагуу хүлээн авч, нэгтгэх, комиссын гишүүдийн урамшууллын тооцооллыг хийж, шийдвэрлүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	2024 оны байдлаар 2 дүгээр улиралд 21 аймаг, 9 дүүргийн 30 салбар комисс нийт 149 удаа хуралдаж 2475 хүүхдийг хурлаар оруулж, үүнээс байнгын асаргааг цуцалсан 141, байнгын асаргаанд шинээр хамруулсан 980, байнгын асаргааг сунгасан 1282, эрүүл мэндийн үйлчилгээнд 660, боловсролын үйлчилгээнд 390 хүүхдийн холбон зуучилсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймаг, дүүргийн салбар комиссын 2024 оны 02 дүгээр сарын тайланг нэгтгэн Төрийн нарийн бичгийн даргын	10-12	90%

					тушаалаар салбар комиссын гишүүдийн улирлын урамшуулал болох 58,908,350 төгрөгийг батлуулж урамшуулал олгосон. 3, 4-р улиралын тайланг нэгтгэн ажилласан цагийн тооцоог хурлаар орсон хүүхдийн тоонд харьцуулан бодож урамшуулал болох 135,436,925 төгрөгийг олгохоор холбогдох бичиг баримтыг нягтланд хүлээлгэн өгсөн.		
Зорилт 4. “Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх”							
5	Арга хэмжээ 4.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас тус улсын “Жайпур фут” хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй тусламжаар гар, хөлийн протез хийх ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Энэтхэг-Монголын эрүүл мэндийн хамтын ажиллагааны төвтэй хамтран Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд “Жайпур фут” төслийг 2024 оны 9 дүгээр сарын 25-наас 11 дүгээр сарын 9 хүртэл төслийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Төслийн хүрээнд Улаанбаатар хотын 284, орон нутгийн 296 нийт 580 хүнд 650 протез хийсэн байна. 582 иргэн 650 гаруй хиймэл хөл, гар, эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө зэрэг олон төрлийн үйлчилгээг үзүүлж ажилласан. Мөн төслийн хүрээнд 5 аймгийн хөгжлийн төвийн протез, ортопедийн үйлдвэрийн ажилчдыг чадавхжуулах сургалт болон туршлага судлах арга хэмжээнүүд зохион байгуулагдсан.	10-12	100%
	Дэд арга хэмжээ 4.1.1. Ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	70%	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/52 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу холбогдох бэлтгэл ажлыг хариуцан ажилласан. Мөн БНЭУ-ын эмч	10-12	100%

					мэргэжилтнүүдийн визний зөвшөөрөл, тоног төхөөрөмжийг хил гаалиар оруулах, протез хийх өрөө тасалгаа бэлдэх, хөдөө орон нутгийн оролцогчдыг саадгүй авчрах зэрэг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.		
Дэд арга хэмжээ: 4.1.2 “Жайпур фүүт” төслийг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн тооцоог хийж шийдвэрлүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	20%		“Жайпур фүүт” төслийг зохион байгуулахад шаардлагатай 58,535,600 /тавин найман сая таван зуун гучин таван мянга зургаан зуун/ төгрөгийн санхүүгийн тооцоог гарган Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд шийдвэрлүүлж Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар батлуулах ажлыг хариуцан зохион байгуулсан.	10-12	100%
Дэд арга хэмжээ: 4.1.3 “Жайпур фүүт” төслийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	10%		Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан М.П.Сингхийн санаачлагаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас тус улсын “Жайпур фуут” хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй тусламжаар гар, хөлийн протез хийх төслийн ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн төслийн арга хэмжээг хариуцан ажиллаж 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хаалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдийн техникч, мэргэжилтнүүдийг БНЭУ-ын Жайпур фуут хүмүүнлэгийн байгууллагын протезын техникчдийг дагалдуулан туршлага судлуулж, энэ чиглэлээр суралцах, мэдлэг чадвараа дээшлүүлэх нөхцөл боломжийг олгохоор болж Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас англи хэлний	10-12	100%

					сургалтад хамрагдах 10 мэргэжилтний мэдээлэл ирснийг Энэтхэг улсын Элчин сайдын яаманд хүргүүлж ажилласан.		
6	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх “Дэмжих төв”-ийн ажлын хэсэгт ажиллаж шаардлагатай ажлуудыг зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%	Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж 3 удаагийн ажлын хэсгийн хурлыг хамтран зохион байгуулж оролцсон. Мөн 2025 онд Дэмжих төвийг санхүүжүүлэн ажиллах чиглэлийн дагуу дэмжих төвийн үйл үйлчилгээ үзүүлэх журам, стандарт, шаардлагатай бичиг баримтыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан шаардлагатай судалгаа мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Мөн дэмжих төвийн үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийн магадлан итгэмжлэлд тавигдах шалгуур үзүүлэлтийг боловсруулах журмын төслийг боловсруулах ажлыг хариуцан ажиллаж байна.	10-12	70%
	Дэд арга хэмжээ 4.2.1. Хүүхдийг ивээх сан “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төслийн хүрээнд зохион байгуулж байгаа холбогдох арга хэмжээнд оролцож арга зүйгээр хангаж ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	“Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүдийг чадавхжуулах” зорилгын хүрээнд 2024 оны 7 дүгээр сараас эхлэн тус төсөлтэй хамтран ажиллалаа. Ингэснээр 3 удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, зорилтот 3 дүүрэг 2 аймгийн салбар комиссын гишүүдийн чадавхыг сайжруулах чиглэлээр үнэлгээ, уулзалт, сургалтын ажлуудыг хамтран зохион байгуулж ажилласан.	10-12	70%
	Дэд арга хэмжээ: 4.2.2. Салбар зөвлөлийн гишүүдэд	Үндсэн арга хэмжээний	0%	30%	Японы Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь”	10-12	70%

зориулсан сургалтыг “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг дэмжих нь” төсөлтэй хамтран зохион байгуулах	гүйцэтгэлд эзлэх хувь			төсөлтэй хамтран зорилтот орон нутгуудын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан. Тус сургалтыг 10 дугаар сарын 8,9 өдрүүдэд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийн салбар комиссын гишүүдэд 10 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд, Сэлэнгэ аймгийн салбар комиссын гишүүдэд 10 дугаар сарын 30-ны өдөр Баянхонгор аймгийн салбар комиссын гишүүдэд тус тус зохион байгуулж ажилласан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал - Комиссын дүрэм - Кейс хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй - Хөгжлийн бэрхшээл, түүний онцлог - Эрт илрүүлэг зэрэг сэдвүүдээр хичээл орж оролцогчдын сургалтын өмнөх болон дараах үнэлгээг нэгтгэн боловсруулж цаашид сайжруулах сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан төсөл болон аймгийн салбар комиссуудад хүргүүлэхээр бэлтгэж байна.		
Дэд арга хэмжээ 4.2.3. “Хүүхдийг ивээх сан” ийн төслийн зөвлөхүүдтэй хамтарч ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	30%	Төслийн зөвлөхүүдтэй хамтран салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтын гарын авлагын эхийг бэлтгэн 250 ширхгийг хэвлүүлэн үйл ажиллагаандаа ашиглахад бэлэн болголоо. Мөн төслийн хүрээнд 2 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж цаашид ирэх онд нийт комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг хүртээмжтэй илүү олон салбар комиссуудыг хамруулахаар ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулах, Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, эцэг эхчүүдэд зориулсан гарын авлагыг нэмэлтээр хэвлүүлэх зэрэг ажлуудыг хамтран хийхээр төлөвлөж байна.	10-12	70%

6	Арга хэмжээ: 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдрийг угтсан 1 сарын аян зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0	100%	Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдрийг угтсан нэг сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд “Хүртээмжид хүрэх зам” өдөрлөг, “Хөгжлийн бэрхшээл судлал” эрдэм шинжилгээний хурал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”, “Хакатон-шинэ санаа шийдэл” шалгаруулах уралдаан, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо үндэсний чуулган”, “Ability expo” нэгдсэн арга хэмжээнүүдийг цуврал байдлаар зохион байгуулсан. Аяны хүрээнд төр, төрийн бус, аж ахуй нэгж байгууллагууд руу 150 гаруй албан бичиг боловсруулан хүргүүлж ажилласан.	10-12	100%
7	Арга хэмжээ 4.4.1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо-2024” “Үндэсний чуулган” зохион байгуулах	Үндэсний чуулганг зохион байгуулсан тоо – 1	0	70%	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, нийгэм, эдийн засагт оролцох оролцоо болон бусад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо-2024 үндэсний чуулганыг амжилттай зохион байгууллаа. Чуулганд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төрийн албан хаагчид болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын 800 орчим төлөөлөл оролцсон. Мөн Энэхүү үндэсний чуулганаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоог хангах төрийн бодлого, тулгамдсан асуудал, Эрх зүйн шинэчлэлт”, Нийгмийн оролцоог хангахад иргэний нийгмийн байгууллагын үүрэг хариуцлага”, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа түншлэл сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж зөвлөмж гаргаж ажилласан. Чуулганы зохион байгуулахад 70 орчим албан бичиг боловсруулан албан байгууллагуудад хүргүүлсэн. Мөн зохион байгуулахад шаардлагатай 224,038,500 /Хоёр зуун хорин дөрвөн сая гучин найман мянга таван зуун төгрөг/-ийн санхүүгийн тооцооллыг гарган	10-12	100%

					Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж шийдвэрлүүлэн төсөвтэй 20 арга хэмжээний гэрээ байгуулан төлбөр тооцоог шилжүүлсэн.		
	Дэд арга хэмжээ: 4.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Ability expo-2024" арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0	30%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг угтсан аяны хүрээнд Ability expo-2024 арга хэмжээг зохион байгуулахад Төр, төрийн бус, аж ахуй нэгж байгууллагууд руу хамтран ажиллах 27 албан бичиг хүргүүлж ажилласан байна. Арга хэмжээ Төр, хувийн хэвшил, иргэдийн уялдаа холбоог сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хувь нэмрээ оруулан хөгжих боломжит орчныг бий болгох, бүрдүүлэх, тэдний нийгмийн оролцоо, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой "ABILITY EXPO" 2024 арга хэмжээг Хайнд Про ХХК санаачлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Төрийн банк, Олон улсын Ротари байгууллага, Мянганы хөгжлийн туурвил ТББ байгууллагууд хамтран 2024 оны 12 сарын 01-ны өдөр UG Arene event palace-д зохион байгуулагдсан. Энэ жил "Бэрхшээл бүхэн Боломж" уриан дор хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэгш эрхтэйгээр хамрагдаж, оролцож чаддаггүй тулгамдсан асуудлуудад шийдэл олох зорилгоор Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөлмөр эрхлэлт, Технологи гэсэн үндсэн 4 чиглэлийн хүрээнд зохион байгуулсан. Өдөрлөгт үзэсгэлэн худалдаанд 25 гаруй байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 12 гаруй байгууллагуудын хүний нөөцийн ажилтан, Хайнд про байгууллагын технологи бүтээгдэхүүний танилцуулга, төрийн байгууллагуудын үйлчилгээний танилцуулга	10-12	100%

					хийгдэж тухайн өдөр 1000 гаруй иргэд хүрэлцэн ирсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ҮАОУА)-ын талаарх талуудын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах		0%	100%	Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ҮАОУА)-ын талаарх талуудын уулзалт, хэлэлцүүлэг”-ийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 10 давхрын хурлын танхимд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн үеэр Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын танилцуулга, Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын талаар зарим оронд хэрэгжүүлж буй байдал, Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын цөм иж бүрдлийн талаарх танилцуулга, Эрүүл мэндийн салбарт Олон Улсын хөгжлийн бэрхшээлийн ангилал (ICD-11)-ыг нэвтрүүлж байгаа талаарх мэдээлэл, АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийсэн “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхжуулах” зөвлөх үйлчилгээний мэдээллийг тус тус танилцуулж, Цаашид хэрэгжүүлэх үйл	10-12	100%

					ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулсан.		
2.	НҮБ-ирсэн зөвлөмж танилцуулах сургалт зохион байгуулах		0%	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын талаарх ойлголт, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг танилцуулах сургалтад хамрагдсан.	10-12	100%
3.	Команд штабын сургуулийн зохион байгуулалтад оролцох		0%	100%	Хүн ам, нийгмийн хамгааллын улсын алба (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам)-д "Команд штабын сургууль"-ийг зохион байгуулахтай холбогдуулан харьяа агентлаг газар, төвийн хурлын тэмдэглэл хөтөлсөн.	10-12	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Байгууллагаас зохион байгуулж буй сургалт, олон нийтийн ажилд тухай бүр идэвхтэй хамрагдах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	2024 оны 9 дүгээр сараас хойш Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн бичиг хэргийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд 2024 оны сүүлийн хагаст 4 өргөдөл, гомдол, 21 албан бичиг цахим програмд бүртгэгдсэнийг бичиг хэргийн дэвтэрт бүртгэн мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгсөн байна. Үүнээс хариуцах асуудлын хүрээнд 17 албан бичиг, 3 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна	9-12	100%

Арга хэмжээ 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар зохион байгуулагдах дотоод гадаад хурал уулзалт, сургалт семинарт чиг үүргийн дагуу тогтмол хамрагдах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	Японы хүүхдийг ивээх сангийн "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд 2 удаагийн сургалтад хамрагдсан байна.	10-12	100%
--	---	----	------	---	-------	------

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ГББГ-ЫН ХБХХХ-ИЙН ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

.....

 /М.МЭНДЭЭ /

(Нэр, гарын үсэг)

.....
 (Огноо)